

**БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН**

Ц.БААТАРХҮҮ

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

2025 оны ... сарын ... өдөр

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1 Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд өнөөгийн татвар, шимтгэлийн тогтолцоо ажил олгогч цалин хөлс нэмэгдүүлэх, ажилтны хөдөлмөрийн үнэлэмжийг бодитоор өсгөх боломжийг хязгаарлаж байна. Илүү цагийн цалин хөлснөөс татвар авч байгаа нь илүү хөдөлмөрлөсөн нь илүү их татвар төлөх, харин ажил хөдөлмөр эрхэлдэггүй хэсэг нь тэдний төлсөн татвараар амьдрах нөхцөлийг бүрдүүлж байгаа нь шударга ёсны зарчимд үл нийцэж байна.

Ажил олгогчдын хувьд цалингийн сангийн зардал, нийгмийн даатгалын шимтгэл болон орлогын албан татвар зэрэг олон давхар татварын ачаалал нь хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, илүү цагийн ажлын хөлсийг бодитоор нэмэгдүүлэхэд эдийн засгийн хувьд хүндрэл учруулдаг. Ийм нөхцөлд ажиллагсдын хувьд илүү цагаар ажиллаж нэмэлт орлого олох нь амьдралд бодит хувь нэмэр оруулахгүй, харин ч өндөр татвар, шимтгэлийн дарамт үүсгэж орлогын үр ашигт байдлыг бууруулж байна. Энэ байдал нь хөдөлмөрийн зах зээлийн идэвхийг бууруулж, иргэд хөдөлмөр эрхлэхийн оронд халамжид хамрагдах сэдлийг бий болгож байна.

Олон улсын сайн туршлагаас үзвэл илүү цагийн цалин хөлсний орлогыг татвар, шимтгэлээс чөлөөлөх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг практик олон оронд хэрэгжиж байна. Жишээлбэл, БНСУ-д илүү цагийн ажлын хөлсийг тусгай нэмэгдэл хэлбэрээр үндсэн татварын хөнгөлөлтөөр дэмждэг, Япон улсад илүү цагийн хөдөлмөрийн орлогыг үндсэн орлогоос ангилан тооцдог, АНУ-ын зарим муж улс илүү цагийн цалинг нийгмийн шимтгэлээс хэсэгчлэн чөлөөлөх зохицуулалттай байдаг нь тухайн орны хөдөлмөр эрхлэлтийн идэвх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж байна.

Монгол Улсын хувьд дээрх туршлагыг нутагшуулах шаардлага үүссэн бөгөөд хөдөлмөрлөсөн нь илүү сайхан амьдрах боломжтой, шударга хөдөлмөрийн зарчмыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцогчдын тоог нэмэгдүүлэх бодит хэрэгцээ тулгамдаж байна. Сүүлийн жилүүдэд халамжийг хавтгайруулсан нь хөдөлмөрийн идэвхийг сулруулж байгаа тухай судалгааны дүн гарсан бөгөөд энэ байдал нь төсвийн ачааллыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлд хомсдол үүсгэх эрсдэлтэй болохыг харуулж байна.

Энэ хуулийн зорилго хөдөлмөрийн үнэлэмжийг шударгаар тогтоож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжийн цалингийн сангийн ачааллыг зохистой түвшинд байлгах, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэнэ.

Хууль хэрэгжсэнээр ажилтан зөвхөн үндсэн цагийн цалин хөлсөнд Хувь хүний орлогын албан татвар төлөх бөгөөд илүү цагийн хөдөлмөрт ногдох цалин хөлс нь дээрх татвар, шимтгэлээс бүрэн чөлөөлөгдөх зохицуулалттай болно. Энэ өөрчлөлт нь өрхийн бодит орлогыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэх урам зоригийг дээшлүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг ахиулах төдийгүй аж ахуйн нэгж байгууллагын цалингийн зардалд ногдох татвар, шимтгэлийн дарамтыг бууруулах бодит шийдэл болж чадах ба уг зохицуулалт нь улсын төсөвт шууд ачаалал үүсгэхгүй.

Илүү хөдөлмөрлөсөн нь илүү сайхан амьдрах зарчмыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн үнэ цэнийг бодитоор үнэлэх, ажил олгогч, ажилтны эрх ашгийг харилцан тэнцвэржүүлсэн энэхүү хууль нь өнөөгийн хөдөлмөрийн зах зээлд тулгамдаж буй бодит асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам болно.

1.2 Практик шаардлага

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулж, нэмэгдэл хөлсний зарим хэсгийг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх үндсэн зорилго нь хөдөлмөр эрхэлж буй иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн үнэлэмжийг шударгаар тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагын цалингийн сан дээр ногдох татвар, шимтгэлийн ачааллыг бууруулах, халамжаас хөдөлмөр эрхлэлтэд шилжих бодлогыг дэмжихэд оршино.

Энэ хууль хэрэгжсэнээр хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцогч иргэд илүү цагийн хөдөлмөр эрхэлсний үр шимийг бодитоор хүртэж, нэмэгдэл орлогоо ямар нэг татвар хураамжгүй бүрэн авч ашиглах боломжтой болно. Энэ нь нэг талаас өрхийн бодит орлого нэмэгдэхэд шууд нөлөөлөх бөгөөд нөгөө талаас ажил олгогч аж ахуйн нэгжүүдэд илүү цагийн хөдөлмөрийн үнэлэмжийг шударгаар тогтоох, бүтээмж өндөр ажилтнуудаа урамшуулах санхүүгийн чадамжийг нэмэгдүүлнэ.

Илүү хөдөлмөрлөсөн нь илүү их орлого олох бодит боломж бүрдсэнээр ажиллах сонирхол, хөдөлмөр эрхлэх идэвх сэргэж, халамжаар амьдрах хандлага аажмаар буурна. Ингэснээр иргэдийн амьжиргааны түвшин тогтвортой дээшилж, хөдөлмөрийн зах зээлийн бүтээмж нэмэгдэж, дундаж давхаргыг бэхжүүлэх нийгэм, эдийн засгийн таатай орчин бүрдэх юм.

Хуулийн төсөл нь хөдөлмөр эрхлэлтийг татвар, шимтгэлийн зохицуулалтаар дэмжих бодлогыг хэрэгжүүлж, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх замаар халамжид хэт хамааралтай иргэдийг хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцоход чиглэнэ. Түүнчлэн ажил олгогчдын хувьд илүү цагийн ажлын хөлсөнд ногдох давхар татвар, шимтгэлийн ачааллыг бууруулснаар цалин хөлсний сангаа зөв удирдах, бүтээмжийг дэмжих боломжтой болж, үйл ажиллагааны үр ашиг дээшилнэ.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд дараах зохицуулалтыг нэмж тусгав. Үүнд: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11-т "...долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баярын өдрөөр ажилласны нэмэгдэл хөлс болон хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтоон олгож байгаа тэдгээртэй адилтгах бусад нэмэгдэл хөлсийг" буюу нэмэгдэл хөлсний зарим хэсгийг хэмээн нэмж албан татвараас чөлөөлөх орлогод хамааруулж тусгав.

Хамрах салбар, хүрээ. Хувь хүний орлогын албан татварын хуульд нэмэлт оруулж, илүү цагийн цалин хөлсний зарим хэсгийг татвараас чөлөөлөх нь Монгол Улсын эдийн засгийн хөдөлгүүр болж буй ачаалал ихтэй ажилладаг, улирлын болон онцгой нөхцөл шаарддаг салбарыг хамарна.

1. Барилга, уул уурхай салбар нь Монгол Улсын эдийн засагт голлох байр суурь эзэлдэг бөгөөд цаг уурын нөхцөл, улирлын онцлогоос шалтгаалан богино хугацаанд өндөр ачаалалттай ажиллахыг шаарддаг. Иймээс эдгээр салбарт ажиллагсдын илүү цагийн хөдөлмөрийг бодитоор үнэлж, тухайн орлогыг татвар, шимтгэлээс чөлөөлснөөр иргэдийн бодит орлого нэмэгдэж, ажлын бүтээмж, чанар сайжирна.
2. Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, сувилагч, яаралтай тусламжийн ажилтнууд бага цалинтай хэр нь өндөр хариуцлага, тасралтгүй ачаалалтай ажилладаг бөгөөд шөнийн цагаар, амралтын өдрүүдэд илүү цагаар ажиллах шаардлагатай болдог. Тэдний илүү цагийн хөдөлмөрийг татвар, шимтгэлээс чөлөөлснөөр энэ салбарын ажиллах нөхцөл сайжирч, урамшууллын тогтолцоо бий болж, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарт эерэг нөлөө үзүүлнэ гэж үзлээ.
3. Цагдаа, онцгой байдал, зэвсэгт хүчин зэрэг хууль, хүчний байгууллагын албан хаагчид өдөр шөнөгүй, олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалах, онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэхдээ эрүүл мэнд, амь насны хайрлалгүй зүтгэдэг. Энэ салбарт ажиллагчдын орлого харьцангуй бага байдаг тул илүү цагийн хөдөлмөрийн орлогыг татвар, шимтгэлийн дарамтаас чөлөөлөх нь алба хаагчдын нийгмийн баталгаа сайжирна.
4. Тээвэр, логистикийн салбар нь Монгол Улсын экспорт, импортын урсгалыг хангаж, эдийн засгийн тасралтгүй эргэлтийг дэмжих чухал үүрэгтэй бөгөөд жолооч, ачигч, агуулахын ажилтнууд уртасгасан цагаар хүнд нөхцөлд ажилладаг. Тэдний илүү цагийн орлогыг татвар, шимтгэлээс чөлөөлснөөр салбарын ажиллах хүчин тогтвортой байхад нөлөөлөх юм.
5. Боловсролын салбарт ажиллагсад буюу багш нарын ажлын ачаалал өндөр боловч цалин орлогын хэмжээ ижил түвшний салбар хүмүүстэй харьцуулахад доогуур хэвээр байна. Багш нар хичээлээс гадуурх сургалт, давтлага, нэмэлт

хичээл өгөх зэргээр илүү цаг ажиллаж олсон орлогыг татвар, шимтгэлээс чөлөөлөх нь багшийн орон тооны хомсдолыг бууруулахад чухал үүрэгтэй.

6. Хөдөө аж ахуйн салбар нь улирлын чанартай, богино хугацаанд өндөр ачаалалттай ажиллахыг шаарддаг онцлогтой салбар юм. Хөдөө аж ахуйн салбар ажиллагсад хаврын тариалалт, намрын ургац хураалтын үед өдөр шөнөгүй ажилладаг бөгөөд илүү цагийн нэмэлт орлогоос татвар, шимтгэл авахгүй байх нь ХАА салбарт ажиллагсдад бодит дэмжлэг болно.

Энэ хууль нь улс орны эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах салбарт ажиллагсдын илүү цагийн цалинг татвар, шимтгэлийн ачааллаас чөлөөлж, хөдөлмөрийн шударга үнэлэмжийг бий болгох, хөдөлмөрлөсөн нь илүү сайн амьдрах нөхцөлөөр хангах замаар улс орны эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх чухал арга хэмжээ болох юм.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хэрэгжсэнээр хөдөлмөрийн үнэлэмж шударга тогтож, хөдөлмөрлөсөн нэг нь хөдөлмөрийнхөө үр шимийг бодитоор хүртдэг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн зохистой тогтолцоо бий болох нөхцөл бүрдэнэ. Ингэснээр:

Нэгдүгээрт, иргэдийн орлого бодитоор нэмэгдэнэ. Илүү цагийн хөдөлмөрийн орлого одоогийн нөхцөлд татвар, шимтгэл суутгах орлого болохын хувьд ажилтны хувьд цэвэр авах дүн харьцангуй бага болж ирдэг. Татвар, шимтгэлийн дарамтгүй болсноор илүү цагийн орлого иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааны түвшнийг дээшлүүлэх бодит хөшүүрэг болно.

Хоёрдугаарт, аж ахуйн нэгж, байгууллагын цалингийн сан дээрх санхүүгийн ачаалал буурна. Одоо ажил олгогчид илүү цагийн хөдөлмөрт төлөх цалин хөлснөөс шимтгэл, татвар төлдөг учраас урамшуулал олгох боломжгүй болдог. Хууль хэрэгжсэнээр ажил олгогчийн зардал шууд цалингийн санд төвлөрч, ажилтанд бүрэн очих тул урамшуулал бодитой болж, ажилтны бүтээмж, идэвх сайжирна.

Гуравдугаарт, хөдөлмөрийн үнэлэмжийг шударгаар тогтоож, илүү хөдөлмөрлөсөн нь илүү сайхан амьдрах нөхцөл бүрдэнэ. Ялангуяа өндөр ачаалалтай ажилладаг барилга, уул уурхай, үйлдвэрлэл, эрүүл мэнд, хууль хүчний байгууллага, тээвэр логистик, боловсрол, хөдөө аж ахуй зэрэг салбарт ажиллах хүчний тогтвортой байдал бий болж, салбарын хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

Дөрөвдүгээрт, хөдөлмөр эрхлэх сонирхлыг дэмжин, халамжаас хамааралтай байдлыг бууруулна. Иргэд ажил хөдөлмөр эрхэлж илүү орлого олох боломжтой болох нь халамжид найддаг байдлыг бууруулж, хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцох сэдлийг төрүүлснээр ажилгүйдлийн түвшин буурч, бүтээмжид суурилсан эдийн засаг бий болно.

Тавдугаарт, олон улсын сайн туршлага нутагшиж, өрсөлдөх чадвар нэмэгдэнэ. Хөдөлмөрийн үнэлэмж зөв тогтоовол бүтээмж өсөж, дундаж давхарга өргөжин, улс орны санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлдэг.

Зургаадугаарт, улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй. Илүү цагийн цалин хөлсний эх үүсвэр нь ажил олгогчийн цалингийн сангаас гарах бөгөөд төрөөс татаас, дэмжлэг шаардахгүй тул төсвийн үр ашигт байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Хууль хэрэгжсэнээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого бодитоор хэрэгжиж, хөдөлмөрийн үнэлэмж шударга тогтож, хөдөлмөрийн үр шимээ зүй ёсоор хүртдэг болно. Энэ хууль батлагдсанаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, аж ахуйн нэгжийн санхүүгийн чадварыг дэмжих, нийгэмд шударга ёсны зарчмыг төлөвшүүлэх цаашлаад Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах чухал суурь нөхцөл болж өгнө гэж үзлээ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хувь хүний орлогын албан татварт нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцэж байгаа бөгөөд тухай хуулийг дагалдан боловсруулах хуулийн төсөлгүй болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ